



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2007 оны 12 сарын 14 өдөр

Дугаар 311

Улаанбаатар хот


Ахмад настны асуудлаар авах зарим  
арга хэмжээний тухай

Монгол улсын “Эрүүл мэндийн тухай” хуулийн 8.1.2 дугаар заалт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2007 оны 47/73 тоот тушаалаар батлагдсан “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал” Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 32, 36 дугаарт заасан үйл ажиллагааны чиглэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь :

1. Аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэгт мөрдөх бүтэц, үйл ажиллагааны стандартын 4.4.5 дугаар заалтын “Бусад” гэсэн хэсэгт хамааруулан аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт, төвд “Ахмадын кабинет”-ийг одоогийн бүтэц, орон тооны хүрээнд байгуулан ажиллуулсугай.

2. “Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл, төвийн ахмад настны кабинетийн үйл ажиллагааны үлгэрчилсэн дүрэм”-ийг хавсралт ёсоор баталсугай.

3. Тушаалыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг Эмнэлгийн тусламжийг удирдах газар (Л. Жамбалжав)-т, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газар (О.Баяр)-т тус тус үүрэг болгосугай.



Б.БАТСЭРЭЭДЭНЭ

Эрүүл мэндийн сайдын 2007 оны  
...<sup>10</sup>...дугаар сарын...<sup>14</sup>...-ны өдрийн  
...<sup>3.11</sup>...тоот тушаалын хавсралт

**Аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн нэгдэл,  
төвийн ахмад настны кабинетын үйл ажиллагааны  
үлгэрчилсэн дүрэм**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Ахмад настны (гериатрийн) кабинет (цаашид “кабинет” гэнэ) нь тухайн дэвсгэр нутагт оршин суугаа ахмад настны эрүүл мэндийн байдал, нас дагаж биед гарах өөрчлөлтийг судлан хяналт тавьж эрт өтлөлтөөс урьдчилан сэргийлэх, идэвхитэй урт наслахад баримтлах, мөрдлөг болгох зүйлсийн талаар зөвлөгөө өгөх эрүүл мэндийн байгууллагын нэгж мөн.

1.2. Кабинетад өтлөхүйн нарийн мэргэжлийн эмч, сувилагчид ажиллах бөгөөд тухайн эрүүл мэндийн байгууллагын орон тоо, бүтцийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаагаа явуулна.

1.3. Кабинет нь Геронтологийн төвөөс арга зүйн зөвлөгөө авч ажиллахын зэрэгцээ бусад нарийн мэргэжлийн кабинет, халамжийн төв, өрх, сум, тосгон, сум дундын эмнэлгийн эмч нартай ажлаа нягт уялдуулан зохион байгуулна.

1.4. Кабинет нь ахмад настнуудад зориулсан шаардлагатай багаж, аппарат болон эрт өтлөлтөөс сэргийлэх, урт наслах арга замыг сурталчилсан ном товхимол, зурагт хуудас, дүрс бичлэгийн кино зэрэг сурталчилгааны материал хэвлүүлэх, хэвлэгдсэн материалаар сургалт, сурталчилгаа явуулах үүрэгтэй.

**Хоёр. Кабинетийн эмч, сувилагчийн үүрэг,  
үйл ажиллагааны үндсэн чиглэл**

2.1. “Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж, шалгуур үзүүлэлтийг биелүүлэн ажиллах аймаг, нийслэл, дүүрэг, сумыг төлөөлсөн нэгж байна.

2.2. Аймаг, нийслэл сум, дүүргийн хэмжээнд байгаа ахмад настны эрүүл мэндийн байдал, нас дагаж биед гарах өөрчлөлтийг судлан хяналт тавих, нэгдсэн бүртгэлтэй байна.

2.3. Кабинет нь дараах үндсэн үүрэг хүлээн ажиллана. Үүнд:

2.3.1. Үйлчлэх хүрээний ахмад настнуудыг эрүүл мэндийн бүлгээр нь ангилах,

2.3.2. Эрт өтлөлт, өвчлөл, осол гэмтлээс урьдчилан сэргийлэх, идэвхитэй урт наслах, эрүүл аж төрөх талаар сургалт, сурталчилгааг ахмад настан, нийт хүн амын дунд хийж мэргэжлийн зөвлөгөө өгөх,

2.3.3. Өрх, сум, тосгон, сум дундын эмнэлгийн болон нийгмийн халамжийн байгууллагын эмч нар болон нийгмийн ажилтнуудад өтлөлтөөс сэргийлэх, ахмад настныг асрах, сувилах талаар сургалт зохион байгуулах,

2.3.4. Үндсэн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмч нартай хамтран жил бүр ахмад настнуудад эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ хийж, өвчтэй ахмад настныг эмчийн байнгын хяналтанд авч эмчлэх, тэднийг нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах,

2.3.5. Асран хамгаалах хүнгүй, ганц бие өндөр настнуудад гэрийн үйлчилгээг зохион байгуулах, тэдэнд үйлчлэх сайн дурын идэвхтэн бэлтгэхэд Геронтологийн төв, өрх, сум, тосгон, сум дундын эмч, халамжийн төв, олон нийтийн байгууллагуудтай хамтран ажиллах,

2.3.6. Ахмад настнуудын эрүүл мэндийн байдал, эмчилгээ, сувилгаа, хөгшрөлтөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр семинар, ярилцлага, онол-практикийн хурал зохион байгуулах, судалгаа шинжилгээ хийх,

2.3.7. Ахмад настнуудын эмчилгээ, сувилгаа, хөдөлмөр зохицуулалт болон нийгмийн бусад асуудлаар холбогдох байгууллагад санал боловсруулан шийдвэрлүүлэх,

2.3.8. "Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр"-ийн болон ахмад настны эрүүл мэндтэй холбоотой бусад тайлан мэдээг ЭМЯ, Геронтологийн төв болон холбогдох байгууллагад заагдсан хугацаанд гаргаж өгч байх,

2.3.9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд байгаа ахмад настны эрүүл мэндийн судалгааг жил бүр гарган нэгдсэн бүртгэлтэй болох,

2.3.10. Ахмадын кабинетийн сувилагч нь шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн сайдын 2004 оны 136 тоот тушаал "Гэрээр үзүүлэх сувилахуйн тусламж, асаргаа сувилгаа хийх журам"-ын дагуу үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах үүрэг хүлээнэ.